

Арбитрын ажиллагаан дахь шүүхийн оролцоо

Яагаад арбитрыг сонгодог бэ

- Олон улсын харилцаа өргөжихийн хэрээр түүнийг зохицуулах эрх зүйн хэм хэмжээ илүү боловсронгуй болж, худалдаа, эдийн засгийн асуудал дотоодын хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээнээс давж улс хоорондын буюу олон улсын түвшинд яригдах болсон.
- Үүнийг дагаад аль нэг улсын шүүхээр бус бизнесийн харилцааны соёл, “lex mercetoria” буюу худалдааны зан заншлыг олон улсын арилжааны гэрээний хувьд өндөр ач холбогдол өгдөг, хурдан шуурхай, ажил хэргийн нэр хүндэд нөлөөлөхгүй нууцлал сайтай, хараат бус, хөндлөнгийн бие даасан, уян хатан шинж чанартай гэх зэргийг харгалзан арбитраар шийдвэрлүүлэх хандлага их байна.

Арбитрын ажиллагаанд шүүх оролцох үндэслэл

Бие даасан байх

- par in parem non habet imperium

тэгш этгээд тэгш этгээдийнхээ дээр эрх мэдэлгүй

Энэ зөвхөн арбитрын шийдвэрийн агуулгыг хянахгүй байхтай холбогддог.

Арбитрын тухай хууль

18.1. Арбитрын бүрэлдэхүүн тухайн маргаан нь арбитрын харьяаллын маргаан мөн эсэх, талууд арбитрын хэлэлцээртэй эсэх, уг хэлэлцээр нь хүчин төгөлдөр эсэхийг өөрөө тогтооно.

31.2. Арбитрын бүрэлдэхүүний бүрэн эрхэд аливаа нотлох баримтыг нотлох чадвартай, хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв эргэлзээгүй болохыг тодорхойлох эрх хамаарна.

Туслалцаа авах болон хяналтын тэнцвэр

- Харин төрийн албадлагын механизмаар хамгаалагдсан, олон жилийн нөр их туршлагатай шүүх байгууллагын туслалцааг арбитр авахгүй байх, арбитрын ажиллагааны явцад талуудын эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, дур зоргын шинжтэй үйлдлийг хязгаарлах чиг үүргийг шүүх хэрэгжүүлэхгүй гэсэн ойлголт биш.
- Нэг талаас арбитрын үзэл баримтлал нь зөвшилцлийн үйл ажиллагааны адилаар орон нутгийн шүүхийн арга хэрэгслээр дамжуулан төрийн механизмын оролцооны эсрэг чиглэсэн байдаг ч нөгөө талаас шүүх л зөвхөн арбитрт тусалж болох эрх хэмжээтэй байна.

Шүүхийн оролцооны зарчим

1. Арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны түргэн шуурхай байх зарчмыг хүндэтгэх,
2. Шударга, хараат бус, бие даасан байх зарчмыг баримтлах,
3. Арбитрын ажиллагаанд хүндрэл, бэрхшээл учруулахгүй байх,
4. Арбитрын ажиллагаанд сайн дураар оролцохгүй байх.

Аливаа улс арбитрын ажиллагаан дахь шүүхийн оролцоог хүлээн зөвшөөрөхдөө арбитрын бие даасан байдлыг хязгаарлахаас илүүтэйгээр нэмэгдүүлэхийг анхаарч байгаагийн учир шалтгаан нь арбитр талуудад өргөн боломж олгодог, тэдгээрийн зөвшөөрлийг үндэслэн маргаан шийдвэрлэх журмаа тогтоодог, иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсэн эрхийг шүүхийн нэгэн адил сэргээдгийн хувьд өөрөө олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хангасан бие даасан байх шаардлагатай байх шалгуурт үндэсний шүүхийн оролцооны түвшин хамааралтай юу гэдэг үзүүлэлт ордог байна.

Шүүхийн оролцооны зарчим ба хязгаар

- Арбитр нь талуудын тохиролцооноос хамаардаг ч хуулиар үүсгэгдсэн тогтолцоо тул хууль нь арбитрыг дотоодын болон олон улсын түвшинд үр нөлөөтэй болгох арга хэрэгсэл болдог. Өөрөөр хэлбэл, шүүх, арбитргүйгээр оршин тогтнож чадах ч арбитр нь шүүхгүйгээр оршин байж чадахгүй.
- Тийм учир шүүх болон арбитрын хамаарал нь хаанаас эхлэн хаана дуусч байгааг зөв тогтоох нь чухал бөгөөд арбитрын ажиллагаан дахь шүүхийн оролцооны гол цөм нь түүний хууль зүйн үндэслэлд орших ба шүүх гагцхүү хуулиар тогтоосон эрх хэмжээнийхээ хүрээнд арбитрын ажиллагаанд оролцож, түүнд дэмжлэг үзүүлж байж арбитр жинхэнэ утгаараа үйл ажиллагаагаа явуулна гэдэгтэй эрдэмтэн, судлаачид маргадаггүй.

Шүүхийн оролцооны үе шат

- Эхний үе шат дахь оролцоо

- A. Арбитрын хэлэлцээртэй холбоотой маргаан,
- B. Арбитрыг байгуулах журамтай холбоотой маргаан,
- C. Шүүхийн харьяаллын талаарх маргаан,

Одоогийн хууль арбитрыг байгуулах тал дээр маргаантай

- Явц дунд дахь оролцоо

- A. Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах,
- B. Нотлох баримт бүрдүүлэхэд туслах,
- C. Талууд тохиролцсон ч арбитрчийг томилж чадахгүй байх үед,
- D. Арбитрчийг татгалзан гаргах асуудлыг шийдвэрлэх.

Шүүхийн оролцооны үе шат

- Төгсгөлийн үе шат дахь оролцоо

A. Арбитрын шийдвэрийг баталгаажуулж гүйцэтгэх хуудас бичих,

B. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох.

- Арбитр албадлагын эрх мэдэлгүй
- Арбитрын хэлэлцээр хүчинтэй эсэхийг шалгах шаардлага
- Түр хамгаалах арга хэмжээ
- Шийдвэр албадан биелүүлэх

Арбитрын хэлэлцээр

- Арбитрын хэлэлцээр бие даасан байх

Үндсэн гэрээ хүчин төгөлдөр эсэхээс үл хамаарч арбитрын хэлэлцээр өөрөө хүчинтэй.

Өөрөөр хэлбэл, талууд үндсэн гэрээ хүчин төгөлдөр бус, аль эсхүл хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцэл гэж маргахаас үл шалтгаалан арбитрын хэлэлцээрийг бие даасан байлгах нь арбитрыг хүлээн зөвшөөрөх, дэмжихэд ач холбогдолтой.

- Заавал гэрээ, хэлэлцээртэй холбоотой маргааныг арбитраар шийдвэрлүүлэн гэсэн утга ойлголт биш.

Хуульд тухайлан шүүхэд харьяалуулснаас бусад бүх төрөл (гэрээ болон хуульд зааснаар үүсэх үүрэг)-ийн хэрэг маргааныг талууд арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцож болно.

- Хэрэглэгчийн гэрээ

Зөвхөн маргаан гарсны дараа арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцох

ХЭХТА

3.1.1."хэрэглэгч" гэж бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээгээ хангахад зориулан захиалж, худалдан авч, үйлчлүүлж байгаа, эсхүл хэрэглэж байгаа хувь хүнийг хэлнэ.

АтХ

8.11.Хэрэглэгчийн эрхтэй холбоотой маргааны тухайд арбитрын хэлэлцээрийг гагцхүү маргаан үүссэний дараа талууд бичгээр тусад нь байгуулах бөгөөд арбитрын ажиллагааны харьяаллыг заасан байна.

Урьдчилан боловсруулсан гэрээ

- Стандарт нөхцөл

Хуучин хуулиар стандарт нөхцөл бүхий гэрээнд арбитрын хэлэлцээр тусгагдсан байвал хүчингүй гэж зохицуулсан бол одоо мөрдөж буй хуульд ийм зохицуулалт байхгүй.

- Стандарт нөхцөл бүхий гэрээний хувьд:

- Арилжааны буюу мэргэжлийн шинжтэй гэрээнд арбитрын хэлэлцээр тусгагдсан бол хүчинтэй
- Харин хэрэглэгчийн гэрээнд арбитрын хэлэлцээр тусгагдсан бол хуульд нийцсэн эсэх талаар маргаантай нөхцөл байдал үүсгэнэ.

- Гайхшруулсан заалт

Олон улсын худалдааны гэрээний юнидройдын зарчмын 2.1.20 дугаар зүйлийн 1-д “Стандарт нөхцөлд оруулан гэж нөгөө тал нь тооцоолох боломжгүй заалт стандарт нөхцөлд тусгагдсан бөгөөд уг заалт түүнийг зөвшөөрч байгаагаа шууд илэрхийлээгүй бол дээрх заалтыг хүчинтэй гэж үзэхгүй” гэж “surprising terms” буюу гайхшруулсан заалт гэж томъёолсон байдаг.

Жишээлбэл:

Үнэтэй машин ХХАГ-нд “талуудын хооронд маргаан гарсан тохиолдолд Хонконгийн Олон улсын арбитраар шийдвэрлүүлнэ” гэсэн заалт хүчинтэй эсэх ?

Арбитр хоорондын харьяаллын маргаан

- Хүсэл зориг давуу

Ерөнхий заалт:

“маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх ба тийнхүү шийдвэрлэж чадахгүй бол арбитраар шийдвэрлүүлнэ”

Олон арбитр үйл ажиллагаа явуулдаг учир энэ заалт хүчинтэй эсэхийг тогтоох шаардлага гарна.

Үүнийг зохигчид анхнаасаа арбитраар маргаанаа хянан шийдвэрлүүлэхээр хүсэл зоригоо илэрхийлсэн хэмээн үзэх, харин аль арбитр тухайн маргааныг хянан шийдвэрлэх нь тусдаа шийдвэрлэх асуудал.

АтХ 18.1, 18.7

Маргаан гарвал шүүх шийдвэрлэх

- Орхигдсон хүсэл зориг

- Тохиромжтой нөхцөлийг тодорхойлох

Гэрээнд эрх, үүргийг тодорхойлоход гол үүрэгтэй нөхцөлөө харилцан тохиролцоогүй бол тухайн нөхцөл байдалд тохиромжтой нөхцөлийг хэрэглэнэ

- Гэрээний мөн чанар, зорилго

Талуудын хүсэл зориг, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил, тухайн салбарын онцлог мэргэжлийн чиг хандлага

Арбитрын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх

- Нотлох баримт бүрдүүлэх

Арбитрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т зааснаар арбитрт нотлох баримт бүрдүүлэхэд нь туслалцаа үзүүлэхийг арбитрын ажиллагаа явагдаж байгаа газрын Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, харин олон улсын арбитрын ажиллагааны хувьд Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хэрэгжүүлнэ.

Анхаарах:

39.1 “...уг хүсэлтийг эрх хэмжээнийхээ хүрээнд хуульд заасан нотлох баримт гаргуулах журмын дагуу шийдвэрлэнэ...” гэдгийг болгоомжтой хэрэглэх.

Талууд арбитрын үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох (equal treatment), мэдүүлэх эрх (right to be heard), талуудын гэрээний эрх чөлөөний зарчим (party autonomy), арбитрын ажиллагааны журмыг өөрөө тогтоох (competence-competence), татгалзах эрхээсээ татгалзах, хуулийн хэм хэмжээ хэрэглэхгүйгээр худалдааны зан заншил, сайн санааны зарчим буюу шударга гэж үзсэн ёс зүйн хэм хэмжээг тус тус баримталдаг.

Маргаан буюу хэргийн үйл баримтад хамааралтай эсэх талаас цензур тавихгүй байх.

Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах

- Маргааныг эцэслэн шийдвэрлэх хүртэл одоогийн байгаа нөхцөл байдлаа хэвээр хадгалах,
- одоогийн, эсхүл учирч болох хохирлыг нэмэгдүүлэх, эсхүл арбитрын ажиллагаанд бэрхшээл учруулах үйлдэл хийхгүй байх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- арбитрын үндсэн шийдвэрийн биелэлтийг хангахад шаардлагатай байж болох хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах,
- маргааныг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой, уг маргаантай холбоотой байж болох нотлох баримтыг хамгаалах

- “status cova”

Талууд маргалдсан ч тэдгээрийн бусад харилцаа хэвийн байх зарчим.

Ялангуяа бизнесийн харилцаанд бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэлд хэрэгтэй түүхий эдээр тасралтгүй хангах, хэрэглэгчийн эрх ашгийн үүднээс стратегийн ач холбогдолтой бараа, ажил үйлчилгээний нийлүүлэлтийг зогсоохгүй байх, улс орныг батлан хамгаалах, дэд бүтцийн салбар дахь тогтвортой байдлыг хангах, татварын орлогыг тасалдуулахгүй байх гэх мэт шалтгаанаар арбитраас, аль эсхүл давж заалдах шатны шүүхээс талуудад өмнөх харилцаагаа муутгахгүй байх, сэргээх үүргийг ногдуулж болно.

- түр арга хэмжээг авахдаа хүсэлт гаргасан байх нь шууд хангах үндэслэл болохгүй юм. Учир нь, дээр дурдсанаар “status cova” зарчмын хүрээнд учирч болох хохирлыг нэмэгдүүлэх, нөгөө талд үндэслэлгүй хохирол учруулахгүй байх, маргаан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин маргаан гаргахгүй байх гэх зэрэг үүднээс Арбитрын тухай хуулийн 20 дугаар зүйлд түр арга хэмжээ авахад тодорхой үндэслэл бүрдсэн байхыг шаарддаг.
- арбитр эсхүл түр арга хэмжээг авсан давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг хүлээн авсан анхан шатны шүүх нь түр арга хэмжээ авах хүсэлт гаргасан талаас санхүүгийн баталгаа гаргахыг шаардах боломжтой. Өөрөөр хэлбэл, үүнийг түр арга хэмжээ авагдсан талд учирсан хохирлыг хожим шууд нөхөн төлөх баталгааг хангахтай холбоотой гэж үзэж байна
- хэрэв шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ болон урьдчилсан тогтоол гаргасан нь хожим шаардлагагүй байсан нь тогтоогдвол нөгөө талд учирсан хохирлыг арбитрын бүрэлдэхүүн нөхөн төлүүлэхээр ажиллагааны аль ч үед шийдвэр гаргадаг нь талууд болон тэдгээрийн бизнесийн харилцааг хүндэтгэж буй давуу тал юм.
- харьяа давж заалдах шатны шүүхүүд арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг авах тохиолдолд татгалзах нөхцөл байгаа эсэхийг талуудын харилцаа, тэдгээрийн үйл ажиллагааны онцлог шинж, учирсан хохирлыг арбитраас шууд нөхөн төлүүлдэг зэргийг харгалзах ёстой.

Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох

Өргөдөл гаргагчийн хүсэлт, түүнээс өгсөн баримтаар:

- Арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр бус байсан,
- Тухайн маргаан нь уг олон улсын арбитрын харъяаллын маргаан биш байсан нь нотлогдсон,
- Арбитрын бүрэлдэхүүн талуудын процессын эрхийг хангаагүй,
- Арбитрын ажиллагааны журмыг арбитрын бүрэлдэхүүн зөрчсөн,
- Арбитрын бүрэлдэхүүн арбитрын хэлэлцээрт хамаарахгүй асуудлаар шийдвэр гаргасан .

Шүүх өөрийн санаачилгаар дараах үндэслэлээр хүчингүй болгох

- Монгол Улсын хуулиар уг маргаан арбитрын харъяаллын маргаан биш,
- Монгол Улсын нийтлэг ашиг сонирхлыг зөрчсөн

/ordre public/

Ordre public

- Эрх зүйн гол үндсэн зарчимд харшилсан /Монгол Улсын Үндсэн хууль/,
- Тухайн улсын хэмжээнд нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахуунд нийцэхгүй /хүмүүсийн ухамсар, шудрага ёс, ёс суртахуун, ёс журам/,

Хязгаарлалт

Гадаад улсын хуулийг хэрэглэх, арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх нь дотоодын хуулиас өөр үр дагаварт хүрч болохыг үгүйсгэхгүй гагцхүү ийнхүү биелүүлснээр эрх зүйн үзэл баримтлал, иргэдийн сэтгэлгээ, ёс зүйд илэрхий харш, гүйцэтгэх ёстой үйлдэл, эс үйлдэхүйн сэтгэлд багтамгүй байх тохиолдолд нийтийн дэг журмыг хамгаалах үндэслэлээр татгалзаж болно.

Онцлог

- Нийтийн дэг журам гэсэн ойлголтыг хэрэглэх хүрээг тогтоох асуудлыг ихэнхи улсууд үндэсний шүүхийн өөрийнхөн шийдвэрлэх эрх хэмжээний асуудал болгон зохицуулсан.
- Улс бүрийн зан заншил, улс төрийн тогтолцоо, эдийн засгийн хөгжил, эрх зүйн соёл, ухамсар нь өөр байдаг, түүнчлэн гадны нөлөөллөөс төрийн бүрэн эрхт байдлыг хамгаалах ашиг сонирхол их байдаг тул арбитрын бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа талуудын иргэний харьяалал, эсхүл шийдвэр биелэгдэх улсын онцлог зэргийг харгалзах шаардлагатай болдог байна.
- Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенцид улс оронд арбитрын шийдвэрийн шууд хүлээн зөвшөөрөх буюу үг дуугүй хүлээн зөвшөөрөх тухай хатуу тогтоосон “jus cogens” императив хэм хэмжээг агуулаагүй, харин тухайн улс орон үндэсний хууль тогтоомждоо тодорхойлох, эсхүл шүүх нийтийн дэг журамд харшилсан үндэслэлээр татгалзах эрхтэй байхаар үүнийг тодорхой бусаар үлдээсэн гэж үзэж болно.

Анхаарах:

Улс орнууд нийтийн дэг журмыг ямар нэг байдлаар томъёолохоос ерөнхийдөө татгалздаг бөгөөд үүнийг судлаач нарын зүгээс үүгээр халхавчлан арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзах шалтаг болгох ёсгүй гэдэг. Тийм ч учраас олон улсад арбитраас шийдвэр гаргахдаа хэргийг шийдвэрлэх эрх хэм хэмжээг сонгон тайлбарлахдаа тухайн улсын хуулийг хэрхэн ойлгох талаар шинжээч томилдог нь арбитрын шийдвэр үндэслэлтэй байхад нөлөөлдөг тул шүүх нь нийтийн дэг журам гэсэн үндэслэлийг заахдаа болгоомжтой хандах ёстой болдог.

Судлаач Э.Байгаль “энэ нь гадаадын эрх зүйг хэрэглэх, хүлээн зөвшөөрөх нь нийтийн дэг журамтай зөрчилдөж байгаа тохиолдолд тухайн сөрөг нөлөөллөөс урьдчилсэн сэргийлэх зорилготой өвөрмөц шинжтэй хамгаалах хавхлага юм” гэжээ.

Спортын арбитрын арбитрч

- Салбарын техник, арга зүйн мэдлэг чадвартай
- Тухайн спортын орчны талаарх ойлголт мэдлэг өндөр
- Үндэсний бус олон улсын гэрээ, дүрэм журмын тусгай мэдлэг сайн
- Тамирчин, ажилтны шилжилт хөдөлгөөн, арилжаа худалдааны талаарх мэдлэг чадвар өндөр
- Зөвхөн тухайн нэг тамирчны асуудал биш олон улс, эсхүл аль нэг улс, тэдгээрийн клуб, салбарын хэмжээний маргаан үүсгэдэг
- Эв нэгдэл, шударга ёсыг илэрхийлдэг тул эв найрамдал, шударга ёсыг дээдэлж, ялгаварлан гадуурхах үзлээс ангид байх
- Тухайн улс, үндэстний онцлог, зан заншил ёс журмыг хүндэтгэх, харгалзах

Чухал онцлог

- Спортын арбитрын субъект зөвхөн тамирчин биш бөгөөд улс, клуб, агент, үндэсний болон олон улсын спортын холбоо, олимпын хороо зэрэг спортын удирдлагын бүх түвшний байгууллага хамаардаг. Тиймээс спортын арбитр бол тамирчны маргаан шийддэг байгууллага биш спортын эко систем дэх бүх оролцогчдын эрх зүйн маргааныг шийдвэрлэх тусгай арбитрын тогтолцоо юм.

Хамаарах этгээд

Спортчин /athlete/

- Мэргэжлийн тамирчин
- Сонирхогч тамирчин /хязгаартай/
- Үндэсний шигшээ багийн тамирчин
- Клубын тамирчин
- Олимп, дэлхийн аваргын тэмцээний оролцогч
- Спортын холбоонд бүртгэлтэй оролцогч

Бусад

- Дасгалжуулагч
- Багш
- Менежер
- Төлөөлөгч /агент/
- Эмч /сэтгэл зүйч/
- Хоол зүйч

Спортын арбитрын харьяалах маргааныг тогтоох

Хамаарч болох онцлог шинжийг тодорхойлох

- Техникийн өндөр мэдлэг шаардагдах
- Шуурхай шийдвэрлэх шаардлага /үл тасалдах/
- Олон улсын шинжтэй /тухайлсан арбитрын харьяалал болоод хэлэлцээр/
- Хуулиар бус дүрэм, журмаар зохицуулдаг
- Ажил хэрэг, салбарын хүрээнд тогтсон заншил

Үл хамаарах онцлог шинжийг тодорхойлох

- Гэмт хэргийн шинжтэй үйлдэл
- Хөдөлмөрийн маргаан – үндсэн эрх /шүүхийн онцгой харьяалал/
- Бусад этгээдтэй байгуулсан өөр төрлийн гэрээ, хэлэлцээртэй холбоотой маргаан
- Бүртгэлийн маргаан
- Салбарын дотоод бус нийтэд хамаарах асуудал

- Сахилгын шийтгэл
- Допингийн хэрэг
- Тэмцээнд оролцуулахгүй байх шийдвэр
- Эрх хасалт
- Цалин урамшуулал
- Шилжилт хөдөлгөөн
- Гэрээ цуцалсан, биелүүлээгүй
- Санхүүгийн шаардлага хангаагүй
- Тоглолт наймаалцсан /эрүүгийн хэргийн шинжгүй

- Хахууль
- Залилан
- Мөнгө угаалт гэх мэт
- Нийгмийн хамгаалал
- Үндсэн эрхийн маргаан
- Холбоо байгуулах, татан буулгах /дампуурал/
- Холбооны хурал зохион байгуулах, шийдвэр гаргалт /нийтийн ашиг сонирхолд хамааралтай бол шүүх харьяалан шийдвэрлэх/

Арбитрын хэлэлцээр

Хэлэлцээртэй гэж үзэх

- Тухайн салбарын дүрмээр
- Талуудын байгуулсан гэрээ, хэлэлцээр
- Талууд өөр бичиг баримтад тусгагдсан арбитрын хэлэлцээрийг иш татсан /гэхдээ хамаарал бүхий байх/
- Аль нэг тал арбитрт хандсан бөгөөд нөгөө тал үл татгалзсан
- Хуулиар шат дараалсан журам тогтоосон

Хэлэлцээртэй гэж үзэх боломжгүй

- Энгийн сонирхогч иргэн
- Найз нөхөд, хамт олны спорт тэмцээн
- Насанд хүрээгүй хүүхдийн спорт /зөвхөн зөвшөөрөл дээр тулгуурладаг тул болгоомжтой хандах/ -ын хувьд хүүхдийн эрх ашиг сонирхлын төлөө шүүх оролцох
- Холбоонд бүртгэлгүй тэмцээн
- Хөгжлийн бэршээлтэй тамирчны эрх ашиг зөрчигдсөн талаарх маргаанд шүүхийн хяналт хэрэгжих

Онцлог маргаан

Хамаарч болох эсэх

- Хүйсийн ангилал тогтоох

Тестостероны түвшинтэй холбоотой маргаан

- Эсхүл тодорхой ангилалд өрсөлдөх эрхтэй эсэх

Жишээ:

Эмэгтэй ангилалд оролцох эрхгүй гэж шийдвэрлэх

- Пара спортод ангиллыг буруу тогтоосон

Үл хамаарах

- Хүний эрх
- Хувийн нууц
- Ялгаварлан гадуурахсан үйлдэл
- Шударга бус өрсөлдөөн

Процессын шударга байдал, нийтийн хэв журам, үндсэн эрхийн хамгаалалт зөрчигдсэн бол шүүхэд хянуулах эрх нээлттэй.

Спортын арбитрын хэрэглэх хэм хэмжээ

- Талуудын байгуулсан гэрээ, хэлэлцээр
- Салбар, клубын дүрэм журам
- Салбар, клубын ажил хэргийн хүрээнд тогтсон зан заншил
- Хууль
- Зарчим

Анхаарах:

- Арбитрын тухай хууль

Арилжааны шинж чанартай хэрэг маргааныг шийдвэрлэх харилцааг зохицуулсан учир спортын арбитрын үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэх талаар судалгаа хэрэгтэй.